

## СҮХБААТАР ДҮҮРГИЙН 2021 ОНЫ 10 ДУГААР САРЫН ЭХНИЙ 14 ХОНОГИЙН ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН

2021 оны 10 дүгээр сарын 14-ний өдөр

Улаанбаатар хот

Сүхбаатар дүүргийн нийт байгууллага, хэлтэс нэгжийн хэмжээнд 2021 оны 10 дугаар сарын эхний 14 хоногт 262 өргөдөл хүсэлт ирсэн байна. Үүнээс хугацаандаа шийдвэрлэгдэж хариу өгсөн 141, судлагдаж байгаа 110 өргөдөл хүсэлт байна. Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн 11 өргөдөл хүсэлт байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн явц 58,00 хувьтай байна.

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 10 хоног 17 цаг 30 минут байна.

Өргөдөл гомдлыг хандалтаар нь авч үзвэл:

1. Санхүү татварын тухай – 81
2. Ажилд орох тухай-14
3. Архивын лавлагаа, мэдээллийн тухай- 12
4. Ажлаас чөлөөлөгдөх тухай-8
5. Өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай-7
6. Дүүргүүдийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, албаны үйл ажиллагааны тухай -4
7. Мөнгөн тусламж хүсэх тухай -3
8. Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааны тухай-3
9. Газрын маргаантай асуудлыг шийдвэрлүүлэх тухай -3
10. Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн тохижилтын тухай-2
11. Бусад 125 өргөдөл хүсэлт байна.

2021 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс 10 дугаар сарын 14-ний өдрийг хүртлэх хугацаанд өргөдөл хүсэлтийг өдөрт нь багтаан хүлээж аваагүй, өдөрт нь багтаан шилжүүлээгүй, явцын тэмдэглэл хөтлөөгүй болон бусад 109 зөрчил бүртгэгдсэн байна.

Эдгээр байгууллагуудад мөн зөрчлийг бууруулах тал дээр анхаарч ажиллах чиглэл хүргүүлж өдөр тутамд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, албан хаагч бүрийн гар утас руу залган мэдээлэл хүргэн ажиллаж байна.

Өргөдөл гомдлын мэдээ тайланг улирал, сар болон тухай бүр гаргаж дээд шатны байгууллагад тайлагнан Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ажиллаж байгаа болно.

Эдгээр байгууллагуудад өргөдөл гомдлын нэгдсэн программын ашиглалтыг сайжруулж өргөдөл гомдлыг хуулийн хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн албан хаагчдад хариуцлага тооцох тухай албан бичгийг хүргүүлэн ажиллаж байна.

Дэргэдэх хэлтэс албадын өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээг сар бүр болон тухай бүр гарган Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хэвшээд байна.

## СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ 10 ДУГААР САРЫН ЭХНИЙ 14 ХОНОГИЙН ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН

Сүхбаатар дүүргийн Засаг даргын тамгын газар 2021 оны 10 дугаар сарын эхний 14 хоногийн байдлаар нийт 48 өргөдөл хүсэлт хүлээн авсан байна. Үүнээс хугацаандаа шийдвэрлэгдэж хариу өгсөн 35, судлагдаж байгаа 12 өргөдөл хүсэлт байна. Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн 1 өргөдөл хүсэлт байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн явц 75,00 хувьтай байна.

Тодруулбал: Хороо бүртгэсэн 18, НҮНТ бүртгэсэн 1, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага бүртгэсэн 20, 1800-1200 дугаарын оператор бүртгэсэн 9, өргөдөл хүсэлт тус тус хүлээн авсан байна.

Өргөдөл гомдлыг хандалтаар нь авч үзвэл:

1. Авто зам, гүүрийн засвар, үйлчилгээний тухай-2
2. Ажилд орох тухай-2
3. Архивын лавлагаа, мэдээллийн тухай-2
4. Ажлаас чөлөөлөгдөх тухай-2
5. Бусад-40

2021 оны 10 дугаар сарын эхний 14 хоногийн байдлаар өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 9 хоног 4 цаг 34 минут байна.

Уг зөрчлийг бууруулах тал дээр анхаарч ажиллах талаар албан хаагч бүрт өдөр тутамд сануулах болон утсаар , ERP програмаар дамжуулан мэдээлэл хүргэн ажиллаж байна.